

Түүх 9: Иаков 1
(Ах дүү хоёрын зөрчилдөөн.)

Библийн эшлэл
[Эхлэл 25:33]

Иаков, Өнөөдөр надад тангарагла! гэсэнд Есав түүнд тангараглаж,
ууган хүү байх эрхээ Иаковт худалджээ.

Исаак Ребека хоёрын дундаас ихэр хөвгүүд мэндэлжээ.

Түрүүлж төрсөн хүү нь улаан арьстай үсэрхэг байв.

Исаак энэ хүүгээ “Есав” гэж нэрлэв.

Дараагийн хүү нь ахынхаа өсгийнөөс зуурч гарсан тул “Иаков” гэж нэрлэжээ.

Есав нь өсөж том болоод зоригтой анчин болжээ.

Харин Иаков нь хонь малаа хариулан, гэрийн ажилд тусалдаг нэгэн байв.

Нэгэн өдөр, Иаков шөл хийж байлаа. Өдөржин ан хийж байгаад ирсэн Есав ихэд өлссөн байв.

Есав дүүдээ ингэж хэлэв. “Иаков! Шөлнөөсөө жаахан өгөөч?”

Иаков хариулав. “Тэгвэл та ууган хүүгийн эрхээ надад өг. Тэгвэл би шөлнөөсөө өгье”

Есав ууган хүү байх эрхээ чухал гэж бодолгүй, дүүгийнхээ хэлснээр хийв.

Цаг хугацаа өнгөрсөөр, Исаак өвгөрөн хөгширчээ. Түүний хоёр нүд нь муудан сайн харж чадахгүй байлаа.

Нэгэн өдөр, Исаак том хүү Есаваа дуудав. “Есав хүү минь, чи миний төлөө ан хийж, өөрийнхөө дуртай хоолыг хийн надад авчирч өгөөч. Тэгээд би чамайг ерөөе.” Гэтэл, эцэг хүү хоёрын яриаг Ребека сонсчихов.

Ребека, Иаков хүүгээ дуудаж ингэж хэлэв.

“Иаков, миний хүү хамгийн сайнаас нь шилж байгаад нэг ишиг аваад ир.

Чи тэр ивээлийг авбал зохино.” Ребека, Иаковын авчирсан ишигээр Исаакийн дуртай хоолыг хийжээ.

Тэгээд Есавын хувцаснаас Иаковт өмсүүлэв.

Мөн Иаковын гар, хөл, хүзүүнд нь ямааны үс наачихжээ.



Иаков ээжийнхээ хийсэн хоолыг барьсаар аав дээрээ очив.

Иаков баригдвал яанаа гэж сандарч зүрх нь хүчтэй дэлсэж байлаа.

Исаак Иаковт хүрч үзэв.

Хөгширч, хараа нь муудсан Исаак Иаковын үс наасан гар хөлийг нь барьж үзээд Есав мөн байна гэж итгэв.

Тэгээд хоолоо идээд, Иаковыг ерөөв.

Хэсэг хугацааны дараа Есав ангаас ирж, хоол хийгээд аав дээрээ очив.

Исаак Есавд “Юу гэнээ? Түрүүхэн би чамайг ерөөсөн шүү дээ” гэж хэлэв.

Есав маш их уурлан, хашхирав. Есав дүү Иаковаа маш ихээр үзэн ядаж байлаа.

Тэгээд Есав өөртөө ингэж амлав.

“Аавыг өнгөрсний дараа би Иаковыг заавал алах болно доо.” гэв.

Есавын үгийг эх Ребека нь нууцаар сонсчихов.

Тэгээд Иаковыг үхүүлэхгүйн тулд ах Лабаных уруу зугтаалгажээ.




- Дараах библийн эшлэлийг дээр нь дагаж бицээд цээжлээрэй. (Эхлэл 25:33)

Ууган хүү байх эрхээ Иаковт худалджээ.

Бүтээлч байцгаая 1.

Шөл бэлтгэхийн тулд саванд байгаа хоолыг хайчилж, наагаарай.



Бүтээлч байцгаа 2. Өнөөдөр юу сурснаа сайн бодонгоо өнгөөр ялгаж будаарай.

